



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/110

Улаанбаатар хот

Төсөл арга хэмжээнд өөрчлөлт
оруулан, зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжүүлэх “Эрүүл мэндийн салбарын их засвар” төсөл арга хэмжээний хүрээнд “Аймаг, сумын эрүүл мэндийн байгуулагуудын их засвар” ажлын 6 дугаарт батлагдсан 69,980,730 /Жаран есөн сая есөн зуун наян мянга долоон зуун гучин/ төгрөгийн төсөвт өртөгтэй Эрүүл мэндийн төвийн их засвар /Завхан, Түдэвтэй/ ажлыг Эрүүл мэндийн яамны их засвар /Улаанбаатар, Сүхбаатар/ төсөл арга хэмжээ болгон өөрчилсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох журмын дагуу санхүүжилтийн эрхийг нээлгэж ажиллахыг Санхүү эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-д тус тус даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080413